



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 47 болон 48 дэх долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 11-р сарын 13-аас 11-р сарын 26-ны байдлаар

Ковид-19 цар тахлын эдийн засаг, санхүүгийн зах зээлд нөлөөлж буй нөлөөллийн эсрэг улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 28 дахь дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **Цар тахлын 2 дахь давалгаагаар өвчлөл хурдтай нэмэгдэж, Евро бүсийн бизнесийн үйл ажиллагаа огцом буураад байна.** Гэсэн хэдий ч КОВИД-19-ийн эсрэг вакцин гаргаж авахад ойрхон байгаа нь **2021 онд бүсийн эдийн засгийн сэргэх найдлага төрүүлж байна.** Өнгөрсөн сард 50 байсан Евро бүсийн PMI индекс 11 дүгээр сард 45.1 болж буурсан нь Reuters-ийн санал асуулгаас 1 пунктээр бага байна. Ингэснээр Евро бүсийн эдийн засаг 4 дүгээр улиралд их хэмжээгээр агших магадлал нэмэгдэж байна. Харин 2021 оны эхний хагаст вакцин гарах хүлээлттэй байгаа нь эдийн засаг ирэх оны 2 дугаар хагаст сэргэнэ гэх эерэг хүлээлтийг бий болгож байна.
- **АНУ-д КОВИД-19-ийн тархалт өндөр хэвээр байгаатай холбоотойгоор эдийн засгийн дарамт өндөр байна.** 11 дүгээр сарын 20-ны долоо хоногт ажилгүйдлийн тусламж хүсэгчдийн тоо хоёр долоо хоног дараалан өсч 778,000 болжээ. Энэ нь цар тахал эхлээд хэдийнээ 8 сар өнгөрсөн хэдий ч ажлын байрны цомхотгол үргэлжилсээр байгааг илтгэж байна. Хэрэглэгчид 10 дугаар сард зарлагаа ердөө 0.5%-иар нэмэгдүүлсэн нь цар тахлын дэгдэлт гарснаас хойших хамгийн сул өсөлт боллоо. Үүний зэрэгцээ орлого 10 дугаар сард 0.7 хувиар буурсан дүнтэй байна. “Moody’s Analytics”-ийн ерөнхий эдийн засагч Марк Занди “Хэрэв ЗГ эдийн засгийг дэмжих төсвийн багц арга хэмжээнүүдээ зогсоовол эдийн засгийн байдал улам хүндрэнэ” гэжээ.
- **КОВИД-19-ийн эсрэг вакцин гарахад ойрхон байгаа нь найдвар төрүүлж байгаа хэдий ч дэлхийн эдийн засгийн сэргэлтэд бодит дэмжлэг болоход хугацаа шаардагдахаар байгааг ОУВС-ийн гүйцэтгэх захирал Кристилина Георгиева G20-ийн дээд хэмжээний уулзалтын өмнө анхаарууллаа.** Мөн санхүүгийн зах зээлд тогтворгүй байдал үүсэх эрсдэлтэйг анхаарууллаа. “КОВИД-19-ийн хямралаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн эрүүл мэндийн тодорхойгүй байдалд улс орнуудын ЗГ-ууд цаашид ч бодлогын хүчтэй арга хэмжээнүүдийг авах шаардлагатай” гэж тэрээр ОУВС-ийн блогт (IMF Blog)-д нийтлэл бичжээ. ОУВС 10 дугаар сарын “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайландаа дэлхийн эдийн засаг 2020 онд 4.4 хувиар агшиж, 2021 онд улс орнууд жигд бус сэргэснээр өсөлт 5.2



хувьтай байхаар тооцож байсан. Гэвч 2021 оны эцэст дэлхийн эдийн засаг цар тахлын өмнөх үеийн төсөөллөөс 6 хувиар бага түвшинд байхыг онцолжээ. Тэрээр улс орнуудыг эдийн засгаа дэмжих төсвийн багц арга хэмжээнүүдээ цаашид үргэлжлүүлж, хамгийн ихээр цар тахлын хямралд өртсөн айл өрх, ажилчид, ААН-д үзүүлэх төсвийн дэмжлэгийг нэмэгдүүлэхийг уриаллаа. Мөн G20-ийн удирдагчдыг ядуу буурай

орнуудын эдийн засгийн сэргэлтэд туслахад дэмжлэг үзүүлэхийг уриалав.

Эх сурвалж:

1. CNN, [Trump administration overrules Jerome Powell and cuts off Fed emergency lending programs](#)
2. Reuters, [Euro zone business activity shrinks but vaccine hopes boost optimism](#)
3. ABC news, [Picture of US economy is worrisome as virus inflicts damage](#)
4. Aljazeera, [IMF urges action as recovery loses steam and COVID-19 surges](#)
5. IMF, [Continued Strong Policy Action to Combat Uncertainty](#)

2

БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **Блүүмберг** Экономиксийн шинжээчдийн төсөөллөөр БНХАУ-ын эдийн засаг 3-р улиралд 4.9 хувиар хүлээлтээс өндөр өссөн гүйцэтгэлийн дараа 4-р улиралд хүлээлтэд ниийцтэйгээр 6.1 хувиар өсч, жилийн дүнгээр **2020 онд 2.2 хувиар өсөхөөр байгаа нь өмнөх төсөөллөөс (2.0%) сайжрахаар байна.** Энэ нь сүүлийн 40 жилийн хамгийн бага өсөлт байх бол, **2021 онд тус эдийн засаг 8.2 хувь** буюу 2011 оноос хойших хамгийн өндөр хувиар өсөхөөр төсөөлжээ. 2020 онд БНХАУ-ын засгийн газрын зарцуулалт үргэлжилж, экспорт нэмэгдэхийн зэрэгцээ КОВИД-19-ийн тархалт 3-р сараас хойш бага түвшинд байгаа зэрэг нь өсөлтөд эерэгээр нөлөөлөхөөр байна. Харин 2021 онд вакцин үйлдвэрлэлтэй холбоотойгоор БНХАУ-ын экспортын өсөлт үргэлжилж, дотоод эрэлт нэмэгдэх, төсвийн зарцуулалт үргэлжлэх хэдий ч энэ оны өндөр дүнгээс алгуур буурч тогтворжино гэсэн суурь таамаглалд үндэслэв.
- **БНХАУ-ын төсвийн алдагдал** 2021 онд ДНБ-ий 3.6 хувьд хүрэхээр байсан

бол тус хэмжээ шинэчилсэн төсөөллөөр 3.0 хувьд хүрч буурах төлөвтэй. Цар тахлын нөлөөг бууруулах дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих хүрээнд батлагдсан 4.6 их наяд юаны тусгай зориулалттай бондын хэмжээ 2021 онд буурах хүлээлтэй байна. **Мөнгөний бодлогын хүрээнд** Хятадын Ардын банк /ХАБ/ 1 жилийн хугацаатай бондын хүүгээ энэ оны 11-р сарын байдлаар 30 пункт бууруулж оны эцэст хэвээр хадгалах, 2021 онд дахин 10 пункт бууруулах хүлээлтэй байна. Дээрх хүчин зүйлсийн нөлөөгөөр БНХАУ-ын эдийн засаг 2021 оны 1-р улиралд 15.2 хувь, 2-р улиралд 7.2 хувь, 3-р улиралд 6.2 хувь, 4-р улиралд 5.9 хувиар тус тус өсөхөөр хүлээлтэй байна.

- **БНХАУ-ын төсвийн хөрөнгө оруулалт** оны эхний 10 сард өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар нэмэгдсэн бөгөөд 2021 онд үргэлжлэх төлөвтэй байна. Харин хувийн сектор дахь хөрөнгө оруулалт оны эхний улиралд 20 хувиар буурч байсан бол тайлант хугацаанд 0.7 хувиар буурснаар агшилт багасав.



- Эдийн засгийн идэвхжлийг илэрхийлэх **өндөр давтамжийн үзүүлэлтүүдийн өсөлт** 11-р сард үргэлжилж, БНХАУ-ын дотоод эдийн засгийн идэвхжил хадгалагдах төлөвтэй. Үүнд:
 - **БНХАУ-ын 1-р зэрэглэлийн хотуудад (Шанхай, Бээжин, Гуанжоу, Шенжэн) үл хөдлөх хөрөнгийн салбар дахь борлуулалт** 11-р сарын 13-ны эцсийн байдлаар цар тахлын өмнөх үеийн түвшнээс 26 хувиар нэмэгдэж, 5 дахь долоо хоногтоо өсөлт нь үргэлжлэв.
 - **Автомашинны борлуулалт** энэ оны 7-р сараас нэмэгдсээр байгаа хэдий ч 11-р сарын 13-ны эцсийн байдлаар цар тахлын өмнөх үеийн түвшнээс 19 хувиар бага байна.
 - **11 хотын метро болон замын хөдөлгөөний систем дэх зорчигчдын тоо (passenger volume)** 9-р сарын 20-ны байдлаар цар тахлын өмнөх үеийн түвшнээс 12 хувиар буурч байсан бол 11-р сарын 20-ны эцсийн байдлаар цар тахлын өмнөх үеийн түвшнээс 6 хувиар бага байв.
 - **Үйлдвэрлэлийн салбар дахь үзүүлэлтүүд дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдснийг илэрхийлж байна.** Газрын тос боловсруулах үйлдвэрийн ашиглалт

11-р сарын 20-ны эцсийн байдлаар цар тахлын өмнөх үеийн түвшнээс 14 хувиар өсөв.

- **Үйлдвэрүүд дэх гангийн нөөц (steel rebar)** цар тахлын өмнөх үеийн түвшинд хүрээд буй нь барилгын салбарын идэвхжлийг илтгэж байна. 10 сарын сүүлээр тус үзүүлэлт цар тахлын өмнөх үеийн түвшнээс 40 хувиар нэмэгдсэн байв.
- **Гашуунсухайтын боомтоор** нэвтэрч буй автомашины жолооч бүрийг Ковид-19-ийн шинжилгээнд хамруулах хүрээнд хилээр гарах хугацаа удааширч тус боомтоор нэвтрэх машины тоо 11-р сарын 23-ны байдлаар 10-аас бага болж буурсан талаар БНХАУ-ын “sxcoal.com” байгууллага мэдээлэв. Түүнчлэн БНХАУ-ын Ганцмод боомт дээрх агуулхууд дахь нөөц 1 сая тонн хүрч буурсан, хил дээр үүсээд буй удааширлын нөлөөгөөр богино хугацаанд нүүрсний үнийг нэмэгдүүлэх нөлөөтэй байна. Энэхүү хүндрэл богино хугацаанд шийдэгдэх хүлээлт үүсгээд байна.

Эх сурвалж:

1. *Bloomberg, China Preview-Industrial Profit Growth Likely Edged up in Oct*
2. *Bloomberg, China Insight-Recovery Continues as Demand and Production Sides*
3. *Bloomberg, China Insight-Riding the 2021 Rebound-Stimulus Taper, Not End*

3 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын Засгийн газар ээлжит бусаар өргөтгөсөн хуралдаан хийж, УОК-ын хуралдаанаас гаргасан шийдвэрийг авч хэлэлцэн Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3-ыг үндэслэн коронавируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан

сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 14 хоногоор буюу 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэл

сунгалаа. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, БНХАУ-ын Засгийн газар хоорондын комиссын XVI хуралдааныг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулав. Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар, БНХАУ-ын Худалдааны сайд Жун Шань нар хамтран даргалж, хоёр улсын холбогдох яам, байгууллагуудын төлөөлөл оролцов. Хуралдааны үеэр Комиссын XV хуралдаанаас хойш хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны явцад гарсан ололт амжилт өндөр, дээд түвшний айлчлалын үеэр тохирсон худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаарх тохиролцооны хэрэгжилтийг дүгнэж, ойрын хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлэх гол зорилт, томоохон арга хэмжээ, хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийн талаар санал солилцож, тодорхой тохиролцоонд хүрлээ. Тухайлбал “Талын зам” болон “Бүс ба зам” санаачилгын бүтээн байгуулалтыг урагшлуулах, хоёр улсын худалдааны эргэлтийг 10 тэрбум ам.долларт хүргэх зорилтод эрт хүрэхийн төлөө идэвхтэй хамтран ажиллах, “Ногоон гарц” түр журам зэрэг арга хэмжээг цаашид ч тогтвортой хэрэгжүүлэх, Уул уурхайн бүтээгдэхүүний худалдааг тогтвортой явуулахын зэрэгцээ уул уурхайн бус салбар, түүний дотор хөнгөн үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагаа, мах, махан бүтээгдэхүүн, хөх тариа, улаан буудайн гурил зэрэг бүтээгдэхүүний худалдааг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх, хоёр улс хоорондын барааны худалдаа болон дамжин өнгөрөх тээвэрлэлтийг дэмжих зорилгоор төмөр замын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхээр тохиролцож, Гашуун сухайт-Ганцмод боомтын төмөр замын улсын

хил нэвтрэх цэгийг тохиролцох болон “Монгол-БНХАУ-ын хилийн төмөр замын хэлэлцээр”-ийг шинэчлэн байгуулах, төмөр замын Ханги-Мандал боомт нээх зэрэг асуудлаар санал солилцов. Мөн БНХАУ-аас Монгол Улсад олгосон хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн төслүүдийн хэрэгжилтийг түргэтгэх чиглэлээр хоёр талын холбогдох байгууллагууд идэвхтэй хамтран ажиллахаар тохиролцов.

“Ковид 19” цар тахалтай тэмцэх чиглэлээр хоёр улс өндөр хариуцлагатай хамтран ажиллаж, харилцан дэмжлэг туслалцаа үзүүлж, мэдээллээ шуурхай үр дүнтэй солилцсоноор хоёр улсын хооронд халдварын тохиолдол гараагүйг цохон тэмдэглэж, халдварын тархалтыг хумих, урьдчилан сэргийлэх чиглэлээр цаашид ч идэвхтэй хамтран ажиллахаар санал нэгдэв.

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо КОВИД-19 цар тахал дотоодод тархаж, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорио тогтоосонтой холбоотойгоор 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр ээлжит бусаар хуралдлаа. Энэхүү хуралдаанаар:

1. Бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх;
2. Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулж 6 хувьд тогтоох;
3. Эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
4. Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг



нэвтрүүлэх багц шийдвэрийг гаргалаа.

Монголбанкнаас Ковид-19 цар тахлын үед эдийн засаг, банк, санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, иргэдийн санхүүгийн дарамтыг зөөлрүүлэх зорилгоор шаардлагатай боломжит арга хэмжээг олон улсын туршлага, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж байна. Энэ арга хэмжээний хүрээнд Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн төлбөрийг 2021 оны 7 дугаар сарын 1-

ний өдрийг хүртэл түр хугацаанд хойшлуулахаар Монголбанк, Сангийн яам, Монголын ипотекийн корпораци, Орон сууцны санхүүжилтийн корпораци ХХК болон арилжааны банкууд хамтран дараах зөвшилцөлд хүрлээ.

Монголбанкнаас 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр арилжааны банкуудад ЗМС-ийн лавлагаа авах хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгжид мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж, харилцагчид бүрэн баталгаажуулалт хийсний үндсэн дээр лавлагааг цахимаар олгож ажиллах чиглэлийг албан тоотоор хүргүүллээ.

- Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 2020 оны 10 дугаар сарын байдлаар **94.4%**-тай, нийт зарлага ба цэвэр зээлийн төлөвлөгөө **83.1%**-тай биелсэн буюу төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 5.6%-аар, төсвийн зарлага төлөвлөснөөс 6.9%-аар бага байна.
- 2020 оны 3 дугаар улиралд эдийн засгийн өсөлт **-7.3%** буюу өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.0 их наяд төгрөгөөр буурсан байна. Үүнийг задаргаагаар нь авч үзвэл:
 - Уул уурхайн салбар -4.3 нэгж хувь,
 - Худалдааны салбар -1.3 нэгж хувь,
 - Тээвэр ба агуулахын салбар -1.5 нэгж хувь,
 - Бүтээгдэхүүний цэвэр албан татвар -1.1 нэгж хувийн өсөлтийг голлон бүрдүүлж байна.
- 2020 оны 2 дугаар улиралд уул уурхайн салбар **-29.4%** (-1.8 их наяд

төгрөг)-ийн өсөлттэй гарлаа. Үүнийг задаргаагаар нь авч үзвэл:


- Уул уурхайн салбарын өсөлтөд нүүрс олборлолт -25.3 нэгж хувь,
- Газрын тос олборлолт -6.4 нэгж хувь,
- Металлын хүдэр олборлолт 1.7 нэгж хувийн нөлөөг үзүүлсэн байна.
- 2020 оны 10 дугаар сарын байдлаар гадаад худалдааны эргэлт **10,432.1 сая ам.доллар** гарч, тэнцэл **1,549.1 сая ам.долларын ашигтай** гарлаа.
- Зөвхөн 10 дугаар сард 839.1 сая ам.долларын экспорт, 508.9 сая ам.долларын импорт хийсэн байна.
- 2020 оны 10 дугаар сарын инфляц улсын хэмжээнд **2.4%**, Улаанбаатар хотын хэмжээнд **2.6%** гарлаа.
- Зээл олголтын хэмжээ 10 дугаар сард 1.8 их наяд төгрөг буюу 9 дүгээр сартай ижил хэмжээнд байна. Харин зээл төлөлт 1.86 их наяд төгрөгөөс 1.94 их наяд төгрөг болж **4.5%**-аар өссөн байна.

САРЫН МЭДЭЭ						
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нэгж	Тайлант үе	Өмнөх үе	Өмнөх оны мөн үе	Өөрчлөлт /2020.09-2020.10/	Өсөлт /өмнөх оны мөн үе/
		/2020.10/	/2020.09/	/2019.10/		
Монгол Улсын нэгдсэн төсөв						
Орлого						
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	тэрбум ₮	7,556.3	6,701.4	8,844.0	12.8%	-14.6%
Татварын орлого	тэрбум ₮	6,865.0	6,090.7	8,011.7	12.7%	-14.3%
Татварын бус орлого	тэрбум ₮	691.3	610.8	832.3	13.2%	-16.9%
Зарлага						
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	тэрбум ₮	10,815.3	9,440.7	8,298.6	14.6%	30.3%
Урсгал зардал	тэрбум ₮	8,635.1	7,497.0	6,539.8	15.2%	32.0%
Хөрөнгийн зардал	тэрбум ₮	2,150.4	1,930.3	1,562.7	11.4%	37.6%
Цэвэр зээл	тэрбум ₮	29.9	13.5	196.1	121.7%	-84.8%
Гадаад худалдаа						
Худалдааны эргэлт	сая \$	10,423.1	9,075.1	11,593.2	14.9%	-10.1%
Экспорт	сая \$	5,986.1	5,147.0	6,528.7	16.3%	-8.3%
Импорт	сая \$	4,437.0	3,928.1	5,064.6	13.0%	-12.4%
Худалдааны тэнцэл	сая \$	1,549.1	1,218.9	1,464.1	27.1%	5.8%
Инфляц						
Жилийн инфляц /Улс/	%	2.4	1.7	7.6	41.2%	-68.4%
Жилийн инфляц /УБ хот/	%	2.6	1.4	8.5	85.7%	-69.4%
Банкны зээлийн тайлан						
Зээлийн хэмжээ						
Олгосон зээл /түхэйн сард/	тэрбум ₮	1,801.9	1,819.1	2,018.2	-0.9%	-10.7%
Төлөгдсөн зээл /түхэйн сард/	тэрбум ₮	1,942.8	1,859.3	1,977.1	4.5%	-1.7%
Зээлийн үлдэгдэл	тэрбум ₮	17,042.9	17,182.1	18,038.9	-0.8%	-5.5%



Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл /2020.10/:

Зураг 1. Төсвийн орлого болон зарлагын динамик, сараар



Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Хүснэгт 1. Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж

	Төсөв	Гүйцэтгэл	Хувь-1	Зөрүү
Татварын орлого	7,196,966.4	6,864,994.9	95.4%	(331,971.5)
Татварын бус орлого	810,929.1	691,335.7	85.3%	(119,593.4)
Нийт орлого ба тусламжийн дүн	8,007,895.5	7,556,330.6	94.4%	(451,564.9)

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк


Хүснэгт 2. Нийт зарлага ба цэвэр зээл

	Төсөв	Гүйцэтгэл	Хувь-1	Зөрүү
Урсгал зардал	9,555,873.7	8,635,124.6	90.4%	(920,749.1)
Хөрөнгийн зардал	3,377,458.0	2,150,353.6	63.7%	(1,227,104.4)
Цэвэр зээл	82,866.1	29,850.9	36.0%	(53,015.2)
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	13,016,197.8	10,815,329.1	83.1%	(2,200,868.7)

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Эдийн засгийн өсөлт /2020 оны 3 дугаар улирал/:


Зураг 2. ДНБ-ний өсөлтийн задаргаа



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Газар

УУ салбарын өсөлт /2020 оны 2 дугаар улирал/:


Зураг 3. Уул уурхайн салбарын өсөлтийн задаргаа



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Газар


Гадаад худалдаа /2020.10/:

Зураг 4. Гадаад худалдааны эргэлтийн өсөлт, сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Зураг 5. Экспорт, импорт, тухайн сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар




Хөрөнгийн зах /2020.11.20/:

Зураг 1. Хөрөнгийн биржийн Тор-20 индекс



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж


Зураг 2. МУ-ын бондуудын өгөөж (%)



Эх сурвалж: Монголбанк

Банкуудын зээлийн тайлан /2020.10/:


Зураг 3. Зээлийн эргэн төлөлт, тэтгэврийн зээлийг хассан



Эх сурвалж: Монголбанк

Инфляц /2020.10/:

Зураг 4. Инфляц, сараар



Эх сурвалж: Монголбанк




5


МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							Товч тайлбар
	Үнэ (-1 day) 2020/10/27	Өөрчлөлт				YoY	
		daily	weekly	monthly	year to date		
Зэс	7387	0.0%	1.7%	9.0%	19.9%	24.7%	Дэлхийн хэмжээнд КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдсэн хэдий ч “Pfizer” вакцины эхний шатны туршилт 90 хувийн үр дүнтэй гарсан нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж үнэ нэмэгдэхэд голлон нөлөөлөв.
Төмрийн хүдэр	121.5	0.0%	-0.8%	5.9%	31.3%	45.6%	БНХАУ энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжсэний үр дүнд төмрийн хүдрийн эрэлт сайн байх төлөвтэй бөгөөд коксжих нүүрсний эрэлт 11-р сард өндөр байхаар байгаа нь үнэ хадгалагдахад нөлөөлж байна.
Алт	1815.8	-0.4%	-3.3%	-5.2%	18.3%	24.3%	Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал өндөр, хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна. Гэсэн хэдий ч “Pfizer” вакцины эхний шатны туршилт 90 хувийн үр дүнтэй байна гэсэн мэдээ зах зээл дэх тодорхой бус байдлыг бууруулж алтны үнийг бууруулахад нөлөөлөв.
Газрын тос (Брент)	47.8	0.1%	6.5%	16.2%	-27.7%	-25.3%	КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдэж байгаатай зэрэгцээд газрын тосны үнэ буурч байна. Гэсэн хэдий ч “Pfizer” вакцины туршилт амжилттай болж буй мэдээ үнэ нэмэгдэхэд нөлөөлөв. Гэсэн хэдий ч олон улсын эрчим хүчний байгууллагын тооцооллоор дэлхийн газрын тосны эрэлт 2021 оны дунд хүртэл төдийлөн нэмэгдэхээргүй байна.

Зураг 1. Дэлхийн зах зээл дээрх алт, төмрийн хүдрийн спот үнэ



Зураг 2. Дэлхийн зах зээл дээрх зэс, газрын тосны үнэ



Эх сурвалж: Блумберг

